

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН ДҮНГИЙН ТУХАЙ

НЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО

Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны 2019 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө аймгийн Засаг даргын 2019 оны 09 сарын 10-ны өдрийн баталсан 1/20 дугаар удирдамжийн дагуу Булган аймгийн Баян-Агт сумын сургуулийн 2018 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд Монгол Улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг шалгаж, зөрчил дутагдал илэрсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу шийдвэрлэх, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, цаашид давтан гаргахгүй байх талаар мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөө өгөхөд чиглэгдлээ.

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА

Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Д.Сарангэрэл, Аудитор Б.Нямсүрэн нар 2019 оны 09 сарын 15-ны өдрөөс ажлын 5 өдөр шалгалтыг хийв.

ГУРАВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Сургуулийн 2018 оны касс, харилцах дансны гүйлгээг санхүүгийн анхан шатны баримттай тулган шалгасны зэрэгцээ цалин хөлс, урамшуулал, албан томилолтын бодолт, олголт, шатахууны олголт түүний зарцуулалтыг автомашины замын хуудастай тулгаж, бараа материалын худалдан авалт, зарцуулалт, эд хөрөнгийн тооллого тооцоо бодолт, санхүү, төсвийн ил тод байдлын хэрэгжилт, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт зэрэг хяналт шалгалтын удирдамжид заагдсан асуудлуудыг бүрэн хамруулан захирал Г.Пүрэвсүрэн, нягтлан бодогч Б.Оюун-Эрдэнэ нярав Ц.Сайнжаргал нарыг байлцуулан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийв.

ДӨРӨВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН ОБЪЕКТЫН ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Булган аймгийн Баян-Агт сумын 12 жилийн сургууль нь Захирал 1, сургалтын менежер 2, нийгмийн ажилтан 1, багш 28, нягтлан бодогч 1, нярав 1, Тогооч 4, байрны багш 1, жижүүр 12, сахиул 1, үйлчлэгч 4, номын санч 1, жижүүр 3, цахилгаанчин 1, эмч 1, манаач 1, галч 6 нийт 66 орон тоотой үйл ажиллагаа явуулж байна. Тус сургуулийн

1-р гарын үсгийг 2018 онд Г.Пүрэвсүрэн, 2-р гарын үсгийг Б.Оюун-Эрдэнэ нар зурж орлого, зарлагын гүйлгээг хийж, хөрөнгө мөнгийг захиран зарцуулж иржээ.

ЗУРГАА. ШАЛГАЛТЫН ЯВЦАД ХИЙГДСЭН АЖИЛ, ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

6.1. Санхүүгийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаар: 2018 онд улсын төсвөөс 664906,9 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн орлого 5400,0 мянган төгрөг нийт 670306,9 мянган төгрөгийн санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэн ажилласан байна. Ажиллагсдын цалин хөлс нэмэгдэл урамшуулалын зардалд 425103,1 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлд 56608,3 мянган төгрөг, тогтмол зардалд 42909,5 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 6696,1 мянган төгрөг, норматив зардалд 44206,8 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал, 1259,1 мянган төгрөг, томилот зочны зардал 285,4 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 1948,10 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 3419,3 мянган төгрөгийн зардал гарсан байна.

Цалин урамшууллын талаар: Баян-Агт сумын засаг даргын 2017 оны 12 сарын 18-ны өдрийн Б/39 тоот тушаалаар сумын Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлт 90%-иар биелсэн тул 1 сарын үдсэн цалин 734,0 мянган төгрөг, аймгийн Засаг даргын 2018 оны 04 сарын 22-ны өдрийн А/233 тоот захирамжаар 1-р улирлын үр дүнгийн урамшуулал 242,2 мянган төгрөг, захирлын Б/24 тоот тушаалаар үр дүнгийн урамшуулалд 9575,0 мянган төгрөг, 2018 оны 4-р сарын 2 -ны өдрийн Б/10 тоот тушаалаар багшийн үр дүнгий урамшуулал 2018 оны 12-21-ны өдрийн Б/48, Б/49 тушаалаар шагнал, 2018 оны 12-р сарын 17-ны өдрийн Б/17 тоот тушаалаар үр дүнгийн урамшуулал олгосон байна.

6.2. Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт: 2018 он

№	Нэр	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	Барилга Байгууламж, оро сууц	1405133224	670371952,5	547493266,5	1528011910
2	Машин тоног төхөөрөмж	122404275,8	2775000		125179275,8
3	Тавилга эд хогшил	79708127,6	8608000		88316127,6
4	Номын фонд	15407455,30	232600		15640055,30
5	Программ	400000			400000
7	Биет бус хөрөнгө газар		39530000		39530000
	Дүн	1623053082, 79	721517552,55	547493266,55	1797077368,7 9

2018 оны эхэнд 1623053,0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө дээр төсвийн хөрөнгөөр 1775,0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 3157,0 мянган төгрөгийн тавилга, 232,6 мянган төгрөгийн ном. Хандив тусламжаар 1000,0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 5451,0 мянган төгрөгийн тавилга, 5000,0 мянган төгрөгийн барилга байгууламж газрын үнэлгээгээр 39530,0 мянган төгрөг нэмэгдэж 721517,5 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж 547493,2 мянган төгрөгийн хөрөнгө хасагдаж оны эцэст 1797077,3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэгдсэн байна.

6.3. Бараа материалын хөдлөл өөрчлөлт:2018 он

№	Тайлангийн нэр	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	Эм боох материал	817100	497000	845300	468800
2	Бичиг хэрэг	2566940	2741190	3816530	1491600
3	Аж ахуйн материал	75461010,79	10502389	10492820	75470579,79
4	Түлш шатахуун	11463543,74	31751940	29942790,54	13272693,20
5	Хүнс	3789155,70	42340928	45071154,90	1058928,80
6	Бэлэн бүтээгдэхүүн	777736		273851	503885
	НИЙТ ДҮН	94875486,23	87833447	90442446,44	92266486,79

2018 оны эхэнд 94875,4 мянган төгрөгийн бараа материал дээр төсвийн хөрөнгөөр 817,1 мянган төгрөгийн эм боох материал, 2741,1 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 10502,3 мянган төгрөгийн аж ахуйн материал, 31751,9 мянган төгрөгийн түлш тослох материал, 42340,9 мянган төгрөгийн хүнсний материал нийт 87833,4 мянган төгрөгийн бараа материал төсвийн хөрөнгөөр авсан байна. Тайлант жилийн хугацаанд 90442,4 мянган төгрөгийн зардал гарч оны эцэст 9226,4 мянган төгрөгийн бараа материал бүртгэгдсэн байна.

6.4. Өглөг, авлагын талаар: 2018 онд өглөг, авлагын тооцоо байхгүй байна

6.5 Шилэн дансны талаар: Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны нэгдсэн системд 2018 төсөв гүйцэтгэлийн 49 мэдээлэл оруулахаас 49 мэдээлэл хугацаанд нь оруулсан. Хөрөнгө оруулалт, тендер худалдан авалтын 39 мэдээлэл оруулахаас 39 мэдээллийг хугацаанд нь оруулж бусад төрлийн 61 мэдээ хугацаанд нь мэдээлсэн байна.

**ДОЛОО. ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН,
ЗӨРЧИГДСӨН ХУУЛЬ, ТОГТООМЖ**

1. 2018 оны 12-р сарын 18-ны өдрийн 345 тоот төлбөрийн хүсэлтээр Д.Мөнгөнгэрэлээс 1100000 төгрөгийн төмс худалдан авсан боловч нярав хүнсний тайланд 825000 төгрөгөөр орлогдож 275000 төгрөгийн төмс тайланд тусгаагүй.
2. Эмийн тайлан 11-р сар 143000 төгрөгийн эм худалдан авсан ч орлогын анхан шатны баримт байхгүй байгаа нь Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7 -д /Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно./ заасныг зөрчсөн

3. 2018 оны 12-р сард Э.Эрдэнэчимэгээс худалдан авсан 157000 төгрөгийн аж ахуйн материалыг онлайн тайланд бүртгэсэн хэдий ч няравын тайланд 150000 төгрөгийн анхан шатны баримт бүрдүүлсэн
4. Түлшний зарцуулалтыг шаардахаар зарцуулдаггүй.
5. Жолоочын замын хуудас 2018 оны 9-р сараас хойш байхгүй

**НАЙМ. АВСАН АРГА ХЭМЖЭЭ, МЭРГЭЖЛИЙН ТУСЛАЛЦАА,
ЗӨВЛӨГӨӨ ӨГСӨН БАЙДАЛ**

Шалгалтын хугацаанд 3 албан тушаалтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, илэрсэн зөрчлийг арилгуулах хугацаатай албан шаардлага өгөв.

ЕС. ДҮГНЭЛТ

Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.5, 13.7 дахь /шинэчилсэн/ заалтууд, няравын тайлан гаргалт анхан шатны баримтын бүрдэлт хангалтгүй.

Ололт дэвшилттэй тал нь эд хөрөнгийн тооллогын бүртгэл, харилцахын баримт, хөтлөлт, материалын эмх цэгц сайн байна.

АРВАН НЭГЭН. ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

Санхүүгийн үйл ажиллагаандаа дотоодын хяналт шалгалтыг тогтмол хийх.
Төсвийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөх
Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлэх

БИЧСЭН: АУДИТОР

Б.НЯМСҮРЭН